



Захиргааны хэм хуульчилсан  
актын улсын нэгдсэн санд  
2019 оны 11 сарын 07  
4510

**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ЖИНСТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2019 оны 10 сарын 28 өдөр

Дугаар 10/02

Бодь

**Г Энгийн хог хаягдлын хураамжийн үнэ  
тарифыг шинэчлэн тогтоох  
тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18.1.2 "д", Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2, Татварын ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.7 дахь заалтуудыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Хуралдаанаас **ТОГТООХ** нь:

1. Сумын нийт өрх, аж ахуйн нэгж албан байгууллага, сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг уул уурхай, аж ахуйн нэгжийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг 1 дүгээр хавсралтаар, айл өрхийн хог хаягдлын хураамжийн хэмжээг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Айл өрх, албан байгууллага, аж ахуй нэгж, үйлдвэр үйлчилгээний газруудад хог хаягдлын үйлчилгээний хураамжийг батлагдсан тарифын дагуу дагаж мөрдүүлж ажиллахыг Байгаль орчны хяналтын улсын байцаагч, Татварын улсын байцаагч, Газрын даамал, багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.
3. Нутаг дэвсгэрийн хэмжээнд хог хаягдлын тухай хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх, хяналт тавих, дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулж хамтран ажиллахыг сумын Засаг дарга /Н.Жаргалсайхан/-д даалгасугай.
4. Тогтоолыг холбогдох байгууллагад хүргүүлж улсын нэгдсэн санд бүртгүүлэх ажлыг зохион байгуулахыг Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /М.Ган-Эрдэнэ/-д даалгасугай.
5. Энэ тогтоол гарсантай холбогдуулж сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2019 оны 10/01 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  Р.БАТЖАРГАЛ

Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2019 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн ээлжит 10 дугаар хуралдааны 10/02 дугаар тогтоолын дүгээр хавсралт



АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГУУДАД ХОГ ХАЯГДЛЫН  
ҮНЭ ТАРИФ ТОГТООСОН ХЭМЖЭЭ

№	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нэр	Хог хаягдлын хураамж	
		Өвөл	Зун
1	2	3	4
<b>Нэг. Аж ахуйн нэгж байгууллагаас авах хураамжийн хэмжээ</b>			
1	Засаг даргын Тамгын газар	15000	15000
2	Ерөнхий боловсролын сургууль	20000	20000
3	Эрүүл мэндийн төв	20000	20000
4	Соёл спортын төв	15000	15000
5	Цэцэрлэг	20000	20000
6	Харилцаа холбоо	5000	5000
7	ХААН банк	20000	20000
8	Төрийн банк	20000	20000
9	Уурын зуух	350.000 /50000 галлагааны үеэр 10 дугаар сараас 5 сар хүртэл нийт 7 сар/	
10	Зочид буудал, зоогийн газар , караоке	20000	20000
11	Хүнс барааны дэлгүүр	5000	5000
12	Үйлдвэрлэл үйлчилгээний газрууд	5000	5000
17	Хайгуулын лицензтэй аж ахуйн нэгжүүд	Жилдээ 300000	

Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2019 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн ээлжит 10 дугаар худалдааны 10/02 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт



АЙЛ ӨРХӨӨС ХУРААХ ХОГ ХАЯГДЛЫН  
ХУРААМЖИЙН ҮНЭ ТАРИФ

№	Айл өрх	Хог хаягдлын хураамж	
		Өвөл	Зун
1	Сумын төвийн айл өрх	5000	3000
2	Хөдөөний алслагдсан багт амьдарч буй айл өрх	1000	1000
3	Дулааны шугам сүлжээнд холбогдсон айл өрх	3000	3000

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_